



ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Х.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014 03 25 № 1/18 ЦАГ-САГ/2014/11/СТА-ТТЗ

Зөрчлийг арилгуулах тухай

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн газрын 2013 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2013 оны санхүүгийн тайланд бүртгэлтэй ашиглагдахгүй байгаа, эвдэрсэн, шаардлага хангахаа больсон 93 нэр төрлийн 198,126,718.67 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна.

Ийнхүү Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгч байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2013 оны санхүүгийн тайланд бүртгэлтэй он удаан жил ашиглагдсан, техникийн хувьд хоцрогдсон, сэлбэг хэрэгсэл нь олдохоо больсон, эвдэрсэн, ажлын шаардлага хангахгүй байгаа 93 нэр төрлийн 198,126,718.67 төгрөгийн үндсэн хөрөнгийн асуудлыг Төрийн өмчийн хороонд танилцуулж, шийдвэр гаргуулах.

Албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 13-ны дотор гарган Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Х.Өлзийбаяр, Санхүү, төлөвлөлтийн тасгийн дарга С.Оргил, нягтлан бодогч Г.Оюунбат нарт хариуцуулав.

АХЛАХ АУДИТОР
ШИНЖЭЭЧ



Б.БОЛОРМАА
О.ДАШЖАМЦ

УХА0122